



МОНГОЛ УЛС
БАЯНХОНГОР АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2023 оны 06 сарын 27 өдөр

Дугаар А/317

Номгон

Эвдэрсэн газрын хяналтын тооллого
зохион байгуулах тухай

Байгаль орчин, аялал жуулчлалын яамны Төрийн нарийн бичгийн даргын 2023 оны 05 дугаар сарын 24-ний өдрийн “Эвдэрсэн болон нөхөн сэргээлт хийгдсэн газрын улсын тооллого зохион байгуулах тухай” 03/2986 дугаар албан бичгийг хэрэгжүүлэх зорилгоор Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.2.3, Сангийн сайдын 2021 оны 61 дүгээр тушаалаар батлагдсан “Засаг даргын нөөц хөрөнгийг зориулалт, зарцуулалтын нийтлэг журам”-ын 2.1.5 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖ нь:

1.Аймгийн хэмжээнд уул уурхайн болон хувиараа ашигт малтмал олборлогчдын үйл ажиллагааны улмаас эвдрэлд орж орхигдсон газрын хяналтын тооллогыг 2023 оны 06 дугаар сарын 09-нөөс 2023 оны 06 дугаар сарын 15-ны өдрүүдийн хооронд зохион байгуулсугай.

2.Хяналтын тооллого зохион байгуулах ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг нэгдүгээр, зардлын тооцоог хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.


3.Хяналтын тооллого зохион байгуулах ажилд шаардагдах 1,724,240 (Нэг сая долоон зуун хорин дөрвөн мянга хоёр зуун дөч) төгрөгийг аймгийн Засаг даргын нөөц хөрөнгөөс зарцуулахыг аймгийн Засаг даргын Тамгын газар (Д.Энхжаргал)-т зөвшөөрсүгэй.

4.Хяналтын тооллого зохион байгуулах ажлыг үр дүнтэй зохион байгуулж, холбогдох тайланг аймгийн Засаг даргын Тамгын газрын архив, Байгаль орчин, аялал жуулчлалын яаманд тус тус хүргүүлж ажиллахыг Ажлын хэсгийн ахлагч (Э.Ганзориг)-т,

642310797

ажлын хэсгийн гишүүдийн томилолтын зардлыг шийдвэрлэж ажиллахыг холбогдох сум, байгууллагын дарга нарт тус тус үүрэг болгосугай.

5.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын орлогч (Б.Батсуурь)-д даалгасугай.

ДАРГА  Д.МӨНХСАЙХАН